



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 5 сарын 23 өдөр

Дугаар 121

Улаанбаатар хот

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Жимобайл вексель” ХХК-ийн гаргаж буй 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, 27 сарын хугацаатай, хөрөнгөөр баталгаажсан нийт 70,000 /далан мянга/ ширхэг баталгаат үнэт цаасыг энэ тогтоолын хавсралтын дагуу бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/-т үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны танилцуулгад тусгасан 70,000 ширхэг баталгаат үнэт цаасыг энэ тогтоолын 1-д заасан нөхцөлөөр үнэт цаас гаргагчид ирүүлсэн хөрөнгө оруулагчдын захиалгын гэрээний дагуу худалдахыг “Жимобайл вексель” ХХК /Б.Үүрцайхбаатар/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг “Жимобайл вексель” ХХК /Б.Үүрцайхбаатар/-д үүрэг болгосугай.

1/ Санхүүгийн зохицуулах хороо нь энэхүү тогтоолын 1-д заасан баталгаат үнэт цаасыг бүртгэсэн нь тухайн үнэт цаас болон түүнийг баталгаажуулж буй нэгдсэн хөрөнгийн багц дахь мэдээлэл нь эрсдэлгүй, үнэн зөв гэсэн баталгаа биш бөгөөд хэрэв тухайн баталгаат үнэт цаасанд эрсдэл гарвал Санхүүгийн зохицуулах хороо хариуцахгүйг мэдэгдэхийн хамт энэ талаар үнэт цаасны танилцуулгад тусгайлан тэмдэглэж хөрөнгө оруулагчдад мэдээлэх;

2/ Баталгаат үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны тайланг 30 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлж, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн төлбөр төлөх, мэдээллээр хангах болон бусад үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлж ажиллах.

4. Энэ тогтоолын 1-д заасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг цаашид хэрэгжүүлж ажиллахыг “Санлавмэд” ХХК /Л.Оюун/-д үүрэг болгосугай.

1/ Хороонд судалгаа, шинжилгээнд шаардлагатай холбогдох мэдээ, мэдээллийг тухай бүр гаргаж ирүүлэх;

2/ Анх бүртгүүлсэн барьцаа хөрөнгийн үнэлгээний нийлбэр дүн, хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны өглөгийн дүн, үндсэн болон хүүгийн төлбөр төлөлтийн талаарх мэдээллийг сар бүр тогтмол Хороонд ирүүлж байх.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 5 дугаар сарын 22-ны
өдрийн 22-р тогтоолын хавсралт

УХА0410 5043239

“Жимобайл вексель” ХХК-ийн гаргаж буй
баталгаат үнэт цаас

Баталгаат үнэт цаасны төрөл	Нэрлэсэн үнэ /төгрөгөөр/	Тоо ширхэг	Жилийн хүү	Хугацаа	Нийт хэмжээ /төгрөгөөр/
Баталгаат үнэт цаас	100,000.00	70,000	13.2%	27 сар	7,000,000,000.00
Нийт	100,000.0	70,000	-	-	7,000,000,000.00